

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ
2020 ОНЫ 03 ДУГААР САРЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2020 оны 03 дугаар сарын 31-ний өдөр

Багануур дүүрэг

№	ҮНДЭСЛЭЛ	ХИЙСЭН АЖЛЫН БИЕЛЭЛТ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУВЬ
1.	2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.1.1	<p>Паркийн цахилгаан хангамжийн техникийн нөхцөлийн асуудлыг шийдвэрлүүлэхээр БХБЯ-наас ЭХЯ-нд албан бичгийг хүргүүлсэн. Гадна инженерийн шугам сүлжээний ажлын зургийн хувьд ус хангамж, ариутгах татуургын зурагт экспертийн өгсөн зөвлөмжийн дагуу нэмэлт өөрчлөлт оруулж баталгаажуулсан.</p> <p>“Мон – Энержи Консалт” ХХК-ийн Паркийн хэсэгчилсэн өрөнхий төлөвлөлт, гадна инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсөл магадлангаар хянацдаж, Барилга хөгжлийн төвийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж өрөнхий дүгнэлтийг гаргуулахаар бэлтгэж байна.</p>	100%
2.	БҮТП-ийн Ерөнхий төлөвлөгөө, инженерийн шугам сүлжээний зураг төсөл	<p>Паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын хүрээнд цахилгаан дамжуулах өндөр хүчдэлийн 4,2 км шугамын шинэчилсэн техникийн нөхцөлийг олгуулахаар ЭХЯ-ны холбогдох мэргэжилтэн болон “МЕСЕС” ХХК-тай уулзалт зохион байгуулсан. “МЕСЕС” ХХК нь цахилгаан хангамжийн өрөнхий схемийн зураглалыг боловсруулж ЭХЯ-нд хүргүүлсэн бөгөөд одоогоор уг техникийн нөхцөлийг олгох ЭХЯ-ны ажлын хэсгийн цахим хурлын тов гараагүй хүлээгдэж байна.</p>	100%
3.	Нийслэлийн Засаг даргын 2019 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн А/619 дүгээр захирамж	<p>Паркийн “Үйлдвэрийн албан kontor”-ын барилгын зураг төслийг гүйцэтгэгч “Нутаг Консалт” ХХК-д холбогдох бичиг баримтуудыг гарган, хангач байгууллагуудаас техникийн нөхцөлийг авч, гадна шугам сүлжээний холболтын цэгийг заалган ажлын зургийг гүйцэтгэсэн бөгөөд Дүүргийн хангач байгууллагатай зөвшилцөний дагуу нэмэлт өөрчлөлт оруулсан.</p> <p>Паркийн захиргаа нэгдсэн үйлчилгээний төвийн барилгын ус хангамж, ариутгах татуургын ажлын зургийг “Багануур УС” ОНӨААТҮГ-ын удирдлагууд болон гүйцэтгэгч байгууллагатай гурвалсан уулзалт зохион байгуулсан зөвшилцэж, техникийн нөхцөлийг дахин шинээр авч, зураг төслийн ажлыг гүйцэтгэхээр шийдвэрлээд байна.</p>	100%
4.	БҮТП-ийн хөгжлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөө	ЗГ-ын Хэрэг эрхлэх газрын даргын 2019 оны 47 тоот тушаалтын 2 дугаар хавсралтын дагуу БҮТП-ийн хөгжлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөөний нэгдүгээр бүлгийн хөгжлийн бодлогын хураангуйн төслийг бэлтгэсэн.	100%
5.		Байгууллагын дүрмийг шинэчлэн боловсруулж, НИТХ-аар батлуулахаар бэлтгэж байна.	60%
6.		“Багануур тохижилт” ОНӨААТҮГ-т автомагистраль зам дагуух хамгаалалтын зурvasны мод усалгааны худгийн систем болон дүүргийн хог хаягдлын шинэ цэгийг ашиглахтай холбоотой санал, зөвлөмжийг “Багануур Үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-ын 2020 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаартай албан бичгээр хүргүүлэв.	100%

7.		ХААИС, ШАУИС, УХЭШХ-тэй хамтын ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг талууд хамтран цахимаар дүгнэж, 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлтийг тусгаж батласан.	
8.	2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.2.3	Дэвшилтэд техник технологийн мэдээллийн сан байгуулсан.	100%
9.	ННЗБ-уудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журмын 1 дүгээр хавсралт	<p>Журмын дагуу дараах биелэлтүүдийг хугацаанд нь хүргүүлж ажиллалаа. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн нэгдүгээр улирлын биелэлт Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн нэгдүгээр улирлын биелэлт Багануур дүүргийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн нэгдүгээр улирлын биелэлт Нэг хот - нэг стандарт зорилтот жилийн нэгдүгээр улирлын биелэлт Нийслэлийн Багануур дүүргийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн нэгдүгээр улирлын биелэлт Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн 1 дүгээр улирлын биелэлт Удирдлагын иргэдтэй хийсэн уулзалтын 1 дүгээр улирлын биелэлт 	100%
10.	Нийслэлийн Засаг даргын 2019 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн А/1054 дүгээр захирамж	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн системийг ашиглах журмын хэрэгжилтийг ханган ажилласан ба “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-т 2020 оны 03 дугаар сарын 31-ний байдлаар хариутай 10, хариугүй 10 бичиг нийт 20 албан бичиг ирсэн ба хариутай бичгийн шийдвэрлэлт, хариугүй бичгийн хаалт тус бүр 100 хувьтай байна. “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-аас ААНБ-уудад нийт 25 хариугүй бичиг явуулсан ба шийдвэрлэлт 100 хувьтай байна.	100%
11.	2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.2.2.1	Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт болон Нийслэлийн Засаг даргын А/108, А/168 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах үүднээс цаг үеийн холбогдох мэдээллийг байгууллагын цахим хуудсанд тухай бүрт нь байршуулан ажилласан.	100%
12.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль	“Багануур Үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул Нийслэл дэх төрийн Аудитын газраас 2020 оны 03 дугаар сарын 12-ны өдөр зөрчилгүй санал дүгнэлт гаргасан.	100%
13.		2020 оны 1 дүгээр улирлын тайлан, баланс гаргахад бэлдэж байна.	80%
14.	Үндэсний архивын газрын даргын 2007 оны 59 дугаар тушаал	Албан хаагчдаас 2019 онд үүсч хөтлөгдсөн баримт бичгийг хуваарийн дагуу бүртгэж, хүлээн авсан.	100%

НЭМЭЛТ АЖИЛ

15.	Нийслэлийн Засаг даргын А/108 дугаар захирамжийн биелэлтийг zendmaal@gmail.com цахим хаягаар 7 хоног бүр хүргүүлж байна.	100%
16.	Нийслэлийн Засаг даргын А/168 дугаар захирамжийн биелэлтийг 14 хоног тутамд НЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлэн ажиллаж байна.	100%
17.	Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн үүрэг, чиглэлийн дагуу мөн иргэд, олон нийтийн шинэ төрлийн корона вирусын халдвараас урьдчилан сэргийлэх, дээд газраас гаргасан холбогдох тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангах үүднээс "Багануур үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨТҮГ нь Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газар, дүүргийн Онцгой комисстoy хамтран ажиллаж, батласан хуваарийн дагуу явган эргүүлийн ажилд хяналт тавьж, дүн мэдээг боловсруулан нэгтгэж, орой бүр 22:00 цагт Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Шуурхай штабт ubhealth2020@gmail.com цахим хаягаар тайллагнан, эргүүлээр ажилласан тоон мэдээг 7 хоногоор нэгтгэж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэст 7 хоног бүрийн баасан гарагт battsoojbcity@gmail.com цахим хаягаар хүргүүлж байна.	100%
18.	НОК-ын 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 08 дугаар хурлын тэмдэглэлийн дагуу Нийслэлийн хэмжээнд шинэ төрлийн COVID-19 вирусын халдвараас урьдчилан сэргийлэх, тархалтын хүрээг өргөжүүлэхгүй байхтай холбоотой авч хэрэгжүүлэх ажлын хүрээнд Онцгой комисс, Нийслэлийн Засаг даргын шуурхай хуралдаан зэрэг цаг тухай бүрт товлогдох хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр шууд гүйцэтгэж байхаар техникийн бэлэн байдлыг хангах чиглэлийн дагуу байгууллагын удирдлага бэлтгэл ажлыг бүрэн хангасан.	100%
19.	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захиргачтай "Үр дүнгийн гэрээ" байгуулахаар "Байгууллагын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө"-г боловсруулан хүргүүлсэн.	100%
20.	Багануур дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсийн 2020 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 44 дугаартай албан бичгийн дагуу Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын төвөөс цаг үеийн нехцэл байдалтай холбогдуулан зохион байгуулж буй "Залуучууд коронавирусын эсрэг нэгдэж байна" аянд БҮТП хамт олноороо нэгдсэн ба мэдээллийг 03 дугаар сарын 25-ны өдөр байгууллагын цахим хаягт байршуулсан.	100%

ХЯНАСАН:
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК
ОНӨТҮГ-ЫН ДАРГА



Ч. ЭЛБЭГСАЙХАН

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН:
ЗАХИРГААНЫ АЛБАНЫ
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Lasmurit

Б. НОМИНЗУЛ